



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/20/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Өлзийт экаунт аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Утас: 88117655 Цахим хаяг: auditulziit@gmail.com</p> <p>Аудитын менежер: Утас: 88087384 Цахим хаяг: auditulziit@gmail.com</p> <p>Аудитор: Утас: 99186670 Цахим хаяг: auditulziit@gmail.com</p>
------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин

бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	430,438,036.34	434,386,622.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	5,781,091.98
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	5,781,091.98
3121	Төгрөг	-	5,781,091.98
	Нэмэлт санхүүжилтийн харилцах		5,781,091.98
33	АВЛАГА	297,553.91	4,685,250.00
335	Бусад авлага	297,553.91	4,685,250.00
3351	Байгууллагаас авах авлага	297,553.91	4,685,250.00
35	БАРАА МАТЕРИАЛ	430,140,482.43	423,920,280.85
351	Түүхий эд материал	282,671,480.07	281,904,390.88
35110	Тусгай зориулалттай материал	86,773,667.20	106,167,868.76
35130	Эм боох материал	195,897,812.87	175,196,522.12
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	540,000.00
354	Хангамжийн материал	147,496,002.36	142,015,889.97
35410	Бичиг хэргийн материал	1,536,410.00	392,840.00
35420	Аж ахуйн материал	65,828,779.00	71,812,429.00
35450	Барилгын материал	252,000.00	-
35460	Хүнсний материал	2,443,720.00	4,116,000.00
35470	Бусад хангамжийн материал	77,408,093.36	65,694,620.97
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,842,860,611.44	3,826,640,565.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,842,860,611.44	3,826,640,565.44
392	Биет хөрөнгө	3,836,739,723.44	3,820,519,677.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,924,821,606.16	2,924,821,606.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(172,405,831.35)	(181,096,243.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	175,751,350.00	175,751,350.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(55,882,900.71)	(69,497,652.71)
39205	Машин тоног төхөөрөмж	1,160,781,629.07	1,179,506,474.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(197,986,789.19)	(209,609,048.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,736,274.30	39,011,274.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,075,614.84)	(38,368,082.48)
393	Биет бус хөрөнгө	6,120,888.00	6,120,888.00
39301	Программ хангамж	980,000.00	980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(980,000.00)	(980,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,120,888.00	6,120,888.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,273,298,647.78	4,261,027,188.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	9,688,499.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	9,688,499.67
413	Өглөг	(0.00)	9,688,499.67
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	9,688,499.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,273,298,647.78	4,251,338,688.60
51	Засгийн газрын хувь оролцоо	4,273,298,647.78	4,251,338,688.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,576,013.97	296,576,013.97
51101	Өмч:-төрийн	296,576,013.97	296,576,013.97
512	Хуримтлагдсан үр дүн	3,823,294,535.85	3,801,334,576.67

Аудитын код: НТАГ-2024/20/НА-СТА-ТШЗ

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	3,823,294,535.85	3,823,294,535.85
51220	Тайлант үеийн үр дүн	-	(21,959,959.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	153,428,097.96	153,428,097.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,273,298,647.78	4,261,027,188.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,146,552,509.89	1,535,476,642.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	651,857,285.89	136,158,102.29
120	Нийтлэг татварын бус орлого	651,857,285.89	136,158,102.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	651,857,285.97	136,158,102.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,356,785.31	9,792,783.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	643,500,500.58	126,365,319.29
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,494,695,224.00	1,399,318,540.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	853,116,500.00	835,838,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	853,116,500.00	835,838,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,078,600.00	3,640,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	2,078,600.00	3,640,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	639,500,124.00	559,839,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	639,500,124.00	559,839,940.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,593,854,515.06	1,557,436,601.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,593,854,515.06	1,557,436,601.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,566,497,253.40	1,548,576,813.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711,883,798.20	739,252,929.42
210101	Үндсэн цалин	482,618,069.42	450,050,731.25
210102	Нэмэгдэл	166,322,418.53	209,531,920.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,612,367.63	30,836,901.68
210104	Урамшуулал	30,330,942.62	48,833,376.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,570,116.00	142,280,987.00
210201	Тэтгэврийн даатгал	74,375,316.00	118,946,487.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,911,200.00	5,833,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,809,000.00	4,666,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	952,200.00	1,166,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,522,400.00	11,667,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,894,650.00	101,724,128.68
210301	Гэрэл, цахилгаан	6,069,432.62	15,201,273.68
210302	Түлш, халаалт	83,469,567.38	76,783,200.00
210303	Цэвэр, бохир ус	10,355,650.00	9,739,655.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,389,215.54	88,953,482.86
210401	Бичиг хэрэг	229,343.00	4,037,610.00
210402	Тээвэр, шатахуун	21,645,500.00	30,108,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,514,372.54	4,195,315.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	9,506,696.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	40,325,461.36
210408	Бараа материал акталсны зардал	-	780,000.00
2105	Норматив зардал	499,146,710.22	388,989,144.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	459,373,160.22	328,269,520.71
210502	Хоол, хүнс	39,773,550.00	29,267,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	31,451,904.00

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,117,315.00	24,108,610.00
210601	Багаж хэрэгсэл	20,000.00	10,056,000.00
210604	Урсгал засвар	26,097,315.00	14,052,610.00
2107	Томилолт, зочны зардал	3,060,000.00	2,061,700.00
210702	Дотоод албан томилолт	3,060,000.00	2,061,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,733,511.00	10,808,139.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	1,470,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,680.00	70,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,400.00	180,199.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	180,199.00	80,400.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	4,200,000.00	8,841,100.00
210807	Газрын төлбөр	-	95,880.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,959,232.00	70,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,701,937.44	50,397,691.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,166,050.00	15,177,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,535,887.44	35,219,891.40
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,357,261.66	8,859,788.40
	Бусад урсгал шилжүүлэг	12,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,000,000.00	-
2135	Төсвөөс захирагчдаас олгосон санхүүжилт	15,357,261.66	8,859,788.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,357,261.66	8,859,788.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	552,697,994.83	(21,959,959.18)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	552,697,994.83	(21,959,959.18)

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,514,539,009.31	1,404,723,626.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,356,785.31	9,792,783.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,356,785.31	9,792,783.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,356,785.31	9,792,783.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,356,785.31	9,792,783.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,506,182,224.00	1,394,930,843.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	853,116,500.00	835,838,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	853,116,500.00	835,838,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,565,600.00	3,937,553.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	13,565,600.00	3,640,000.00
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих-Нэмэлт	-	297,553.91
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	639,500,124.00	555,154,690.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	639,500,124.00	555,154,690.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,514,539,009.31	1,397,742,634.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,514,539,009.31	1,397,742,634.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,486,884,193.74	1,388,882,846.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711,883,798.20	739,252,929.42
210101	Үндсэн цалин	482,618,069.42	450,050,731.25
210102	Нэмэгдэл	166,322,418.53	209,531,920.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,612,367.63	30,836,901.68
210104	Урамшуулал	30,330,942.62	48,833,376.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,570,116.00	142,280,987.00
210201	Тэтгэврийн даатгал	74,375,316.00	118,946,487.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,911,200.00	5,833,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,809,000.00	4,666,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	952,200.00	1,166,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,522,400.00	11,667,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,894,650.00	101,724,128.68
210301	Гэрэл, цахилгаан	6,069,432.62	15,201,273.68
210302	Түлш, халаалт	83,469,567.38	76,783,200.00
210303	Цэвэр, бохир ус	10,355,650.00	9,739,655.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,161,699.54	37,222,611.50
210401	Бичиг хэрэг	1,941,870.00	1,170,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,645,500.00	30,108,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,514,372.54	4,195,315.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,059,957.00	1,748,896.00
2105	Норматив зардал	432,484,019.00	299,774,210.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	390,146,219.00	266,902,810.93
210502	Хоол, хүнс	38,397,000.00	30,940,000.00

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,940,800.00	1,931,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,267,350.00	30,675,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,257,550.00	30,180,100.00
210604	Урсгал засвар	1,009,800.00	494,900.00
2107	Томилолт, зочны зардал	3,060,000.00	2,061,700.00
210702	Дотоод албан томилолт	3,060,000.00	2,061,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,733,511.00	11,325,979.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	1,470,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,680.00	70,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,800.00	180,199.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	180,199.00	80,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,365,000.00	8,841,100.00
210807	Газрын төлбөр	497,832.00	95,880.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	588,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,829,050.00	24,565,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,829,050.00	24,565,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,654,815.57	8,859,788.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,000,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт шилжүүлэг	15,654,815.57	8,859,788.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,654,815.57	8,859,788.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	6,980,991.98
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,199,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,199,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,199,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,199,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,199,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	5,781,091.98
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,781,091.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,576,013.97	153,428,097.96	3,270,596,541.02	3,720,600,652.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,576,013.97	153,428,097.96	3,270,596,541.02	3,720,600,652.95
Тайлант үеийн үр дүн			552,697,994.83	552,697,994.83
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,576,013.97	153,428,097.96	3,823,294,535.85	4,273,298,647.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	296,576,013.97	153,428,097.96	3,823,294,535.85	4,273,298,647.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/	0	0	(21,959,959.18)	(21,959,959.18)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,576,013.97	153,428,097.96	3,801,334,576.67	4,251,338,688.60

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	835,838,600.00	835,284,094.60	554,505.40	99.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	835,838,600.00	835,284,094.60	554,505.40	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	835,838,600.00	835,284,094.60	554,505.40	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,368,300.00	563,368,295.42	4.58	100.0
Үндсэн цалин	306,736,600.00	294,902,569.50	11,834,030.50	96.1
Нэмэгдэл	174,790,600.00	189,183,844.17	(14,393,244.17)	108.2
Унаа хоолны хөнгөлөлт	35,805,000.00	30,480,962.28	5,324,037.72	85.1
Урамшуулал	46,036,100.00	48,800,919.47	(2,764,819.47)	106.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	72,921,000.00	72,920,800.00	(200.00)	100.0
Тэтгэврийн даатгал	49,586,300.00	49,586,300.00		100.0
Тэтгэмжийн даатгал	5,833,700.00	5,833,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	4,666,900.00	4,666,900.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,166,700.00	1,166,700.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	11,667,400.00	11,667,200.00	200.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,840,500.00	101,724,128.68	116,371.32	99.9
Гэрэл, цахилгаан	14,152,500.00	15,201,273.68	(1,048,773.68)	107.4
Түлш, халаалт	76,709,500.00	76,783,200.00	(73,700.00)	100.1
Цэвэр, бохир ус	10,978,500.00	9,739,655.00	1,238,845.00	88.7
Хангамж, бараа материалын зардал	17,722,700.00	17,722,611.50	88.50	100.0
Бичиг хэрэг	951,700.00	1,170,000.00	(218,300.00)	122.9
Тээвэр, шатахуун	10,608,400.00	10,608,400.00		100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,783,600.00	4,195,315.50	588,284.50	87.7
Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийг устгал	1,379,000.00	1,748,896.00	(369,896.00)	126.8
Норматив зардал	68,992,800.00	68,992,080.00	720.00	100.0
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,241,600.00	48,240,880.00	720.00	100.0
Хоол, хүнс	18,819,800.00	18,819,800.00		100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,931,400.00	1,931,400.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,446,100.00	1,445,600.00	500.00	100.0
Багаж, техник хэрэгсэл	951,200.00	950,700.00	500.00	99.9
Урсгал засвар	494,900.00	494,900.00	-	100.0
Томилолт, зочны зардал	1,499,700.00	1,499,700.00		100.0
Дотоод албан томилолт	1,499,700.00	1,499,700.00		100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	7,354,500.00	6,917,879.00	436,621.00	94.1

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт зэрэглэл	1,470,300.00	1,470,300.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	76,000.00	70,000.00	6,000.00	92.1
Тээврийн хэрэгслийн татвар	194,100.00	180,199.00	13,901.00	92.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	98,000.00	80,400.00	17,600.00	82.0
Мэдээллийн технологийн зардал	4,433,000.00	4,433,000.00		100.0
Газрын төлбөр	250,000.00	95,880.00	154,120.00	38.4
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	245,000.00	-	245,000.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	588,100.00	588,100.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	693,000.00	693,300.00		100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	835,838,600.00	835,284,094.60	554,505.40	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	835,838,600.00	835,284,094.60	554,505.40	99.9
Улсын төсвөөс санхүүжих	835,838,600.00	835,284,094.60	554,505.40	99.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	33.00	33.00	-	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	16.00	17.00	(1.00)	106.3
Үйлчлэх ажилтан	16.00	15.00	1.00	93.8

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	653,355,424.00	554,798,651.93
УРСГАЛ ЗАРДАЛ	-	554,798,651.93
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	652,927,870.09	554,798,651.93
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,162,535.09	175,884,634.00
Үндсэн цалин	235,292,535.09	155,148,161.75
Нэмэгдэл	-	20,348,075.85
Унаа хоолны хөнгөлөлт	-	355,939.40
Урамшуулал	11,870,000.00	32,457.00
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	34,054,916.00	69,360,187.00
Тэтгэврийн даатгал	30,904,916.00	69,360,187.00
Тэтгэмжийн даатгал	3,150,000.00	-
Хангамж, бараа материалын зардал	-	19,500,000.00
Тээвэр, шатахуун	-	19,500,000.00
Норматив зардал	281,901,619.00	230,782,130.93
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	281,901,619.00	218,661,930.93
Хоол хүнс	-	12,120,200.00
Эд хогшил, урсгал засварын зардал	39,316,750.00	30,429,300.00
Багаж, техник хэрэгсэл	39,316,750.00	30,429,300.00
Томилот, зочны зардал	-	562,000.00
Дотоод албан томилот	-	562,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	4,408,100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,408,100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	50,492,050.00	23,872,300.00
Бараа үйлчилгээний бусад зардал	50,492,050.00	23,872,300.00
Бусад урсгал шилжүүлэг	130,000.00	-
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	130,000.00	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	297,553.91	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	653,355,424.00	560,579,743.91
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	555,154,690.00
Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих	-	555,154,690.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,487,500.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,487,500.00
НЭМГ-аас санхүүжих	2,078,600.00	-
Эрүүл мэндийн даатгалын санхүүжих	638,163,124.00	-
Туслах үйл ажиллагааны орлого	1,626,700.00	-
Урьд оны авлага	11,487,000.00	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,937,553.91
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдийн авсан хандив тусламж	-	3,640,000.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	297,553.91
Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,781,091.98

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрүүл мэндийн төвийн чиг үүрэг нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын дагуу зонхилон тохиолдох халдварт бус өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар нас баралтын хувийг бууруулах зорилтын хүрээнд 6, зонхилон тохиолдох халдварт бус өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар нас баралтын хувийг бууруулах зорилтын хүрээнд 4, товлолд дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдол буурах зорилтын хүрээнд 2, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгохтой холбоотой 2, эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөрийг үргэлжлүүлж ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах зорилтын хүрээнд 2, иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах, тандах эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулах 2, Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн судалгаа гаргах, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлж, жирэмсний эрт хяналтын хувийг нэмэгдүүлэх чиглэлээр 5 үйл ажиллагаа нийт 72 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус төв нь Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газарт чиг үүргийн дагуу харьяалагдан эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд мөрддөг хууль, журам, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд ажилладаг.

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас бүтцийг 32 орон тоотой ажиллахаар баталсан. Байгууллага нь 2023 онд 32 хүний орон тоотой ажилласан. Үүнд удирдах албаны 1, эмнэл зүйн мэргэжилтэн 26, аж ахуйн хэсгийн 5 ажилтан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллага нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, өөрийн орлогын эх үүсвэрээр санхүүждэг. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах”
- Эрүүл мэндийн яамны сайдын 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/139 дугаар тушаалаар “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношилгоо”-г зохион байгуулах журам
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (батлагдсан:2022-11-04 хэрэгжиж эхлэх:2023-03-01)
- Монгол улсын үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай

- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2022 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,271.4 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		5,781.1	5,781.1
Авлага	297.5	4,685.3	4,387.8
Бараа материал	430,140.5	423,920.3	(6,220.2)
Үндсэн хөрөнгө	3,842,860.6	3,826,640.5	(16,220.1)
Нийт хөрөнгө	4,273,298.6	4,261,027.2	(12,271.4)
Өр төлбөр		9,688.5	9,688.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,273,298.6	4,251,338.7	(21,959.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,273,298.6	4,261,027.2	(12,271.4)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,781.1 мянган төгрөгөөр өссөн Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт нь оны эцэст хийгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 4,387.8 мянган төгрөг болж өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага болох ЭМДЕГ-аас санхүүжилт дутуу авсантай холбоотой бөгөөд урд оноос төлөгдөөгүй авлагын үлдэгдэл байхгүй.

Аудитын код: НТАГ-2024/20/НА-СТА-ТШЗ

Бараа материалын дансны үлдэгдэл 6,220.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээ зарцуулснаас шалтгаалсан. Ковид-19 цар тахлын үеэр ЭМЯ-аас нийлүүлсэн 5,066.0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл ашиглалтгүй үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,826,640.5 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 16,220.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,199.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан ЭМЯ-аас 13,079.2 мянга, НЭМГ-аас 4,720.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж тайлант үеийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 9,688.5 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийн үлдэгдлийг тайлант онд төлж барагдуулаагүйтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо данс 4,251,338.7 мянган төгрөг болж 21,959.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 711,851.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардлыг 112,471.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,123.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс, цалин хөлсний нэмэгдлийг дутуу тооцсоноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 123,987.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 835,838.6 мянган төгрөгийг улсын төсвийн орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 835,838.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 8,305.3 мянган төгрөг бүрдүүлж, үйл ажиллагаандаа 835,284.1 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 8,859.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 835,284.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлыг 116.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 438.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	835,838.6	835,284.1	554.5	99.9%
2	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	835,145.6	834,591.1	554.5	99.9%
3	83112-Бусад урсгал шилжүүлэг	693.0	693.0	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд ЭМД-ын сангаас гүйцэтгэлийн санхүүжилтээр 555,154.7 мянга, хэвтэн эмчлүүлэгчдийн ор хоногийн төлбөр 1,487.5 мянга, ХӨСҮТ-өөс томуугүйн вакцины зардалд 1,290.0 мянга, Багахангай дүүргийн ИТХ-аас ДОХ-той тэмцэх санхүүжилт 2,350.0 мянга, урьд оны үлдэгдлээс 297,6 мянга нийт 560,579.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв нь нэмэлт санхүүжилтийн дансаар авсан санхүүжилтийг зориулалтын дагуу 554,798.6 мянган төгрөгийг зарцуулж 5,781.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд нийт 90,749.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс хоол хүнсний бүтээгдэхүүнийг 31,212.8 мянган төгрөг, хог устгал, бичиг хэргийн материалыг 2,408.5 мянган төгрөг, нийт 33,621.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар, 8,428.5 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг 24 удаагийн цахим худалдан авалтаар авсан бол 48,700.0 мянган төгрөгийн эм,эмнэлгийн хэрэгслийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын зохион байгуулсан худалдан авалтаар авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, эд хөрөнгийн тооллогыг үр нөлөөтэй хийх, томилолт, түлш шатахууны тооцоог бодож зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн ахлах аудитор Ч.Эрдэнэжав, аудитор Ч.Оюун, гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Ц.Бямбажав анхан шатны чанарын хяналтыг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,592,815.10 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 15,928.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 116.4 мянган төгрөгийн байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 438.1 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв нь нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс, 13 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх," 6 дугаар зүйлийн 6.4.5. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 1,061,088.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгсөн. Үүнд: Бараа материалын тооллого хийгээгүй, И баримтын бүрдүүлэлт дутуу, цалин хөлсийг НДШ, ХХОАТ-ын тайланд зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчлийг гаргасан байна.

Завсрын аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 7,784.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 56,055.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг 75.0 хувь, 50,306.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг 82 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	7,784.0	2	7,784.0	100%
Албан шаардлага	4	56,055.9	3	56,055.9	75%
Зөвлөмж	1	50,306.2	1	41,201.8	82%
Нийт дүн	7	114,146.1	6	105,041.7	85%

Өмнөх оны аудитаар өгсөн анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй албан шаардлагыг биелүүлээгүй, и баримттай худалдан авалтыг хийж баталгаажуулаагүй албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үнэ төлбөргүй хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгсэлийн зарцуулалт, ашиглах хугацааг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 573,944.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- 2023 оны эхний хагас жилийн цалингийн хүснэгтийг НДШ-ийн тайлан, ХХОАТ-ын тайлантай тулган шалгахад НДШ-ийн тайланг 10,914.7 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын тайланг 954.8 мянган төгрөгөөр тус бүр илүү, Даатгуулагчийн НДШ-ийг 1,250.8 мянган төгрөгөөр, Ажил олгогчийн НДШ-ийг 2,487.5 мянган төгрөгөөр нийт 15,607.8 мянган төгрөгийн зөрүүтэй дутуу тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" гэж заасныг зөрчсөн; УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн 558,336.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын сангаас санхүүжих гэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" гэж заасныг зөрчсөн, УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 12,723.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 682.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 12,041.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Их хэмжээгээр нөөц үүсгэх шаардлагагүй 682.0 мянган төгрөгийн ашиглалтгүй бараа материалын үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" заалттай нийцээгүй.

2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу /цахим и баримт/ 9,104.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгэж тайлагнасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалттай нийцээгүй.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Жилийн эцсийн бараа материалын тооллогыг 540.0 мянган төгрөгөөр санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй тоолсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 1-т үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, 2-т түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Няравын тайлангийн үлдэгдлийг үнэн зөв тоолж баталгаажуулах, тооллогын үр дүнг дүгнэн санхүүгийн тайланд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт-2: Түлш, шатахууны эхний үлдэгдэл 126.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 209.6 мянган төгрөгийг бараа материалын тайланд тусгаагүй, түлш шатахууны тайлан бэлтгэхдээ жолооч нартай спидометрийн заалтаар шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоо бодоогүй нийт 335.7 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж ажиллаагүй...

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

2. Томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт-3: Байгууллагын эрх бүхий албан тушаалтан томилолтын зардлын төсвийг батлаагүй, томилолтоор ажилласан тухай тайлан бичиж тайлагнаагүй 2,061.7 мянган төгрөг зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Томилолтын зардлын төсвийг хянаж баталгаажуулан, томилолтоор ажилласан тайланг бичиж тайлагнаж хэвших зөвлөмж хүргүүлэх

3. Санхүүгийн тайлангийн хугацаатай холбоотой.

Илрүүлэлт-4: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1. "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн

Нийслэлийн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” заалтыг хэрэгжүүлээгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэн ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү .

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл										/мянган төгрөгөөр/	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчдын цалин хөлснөөс НДШ, ХХОАТ-ыг суутган тооцоолохдоо зөрүүтэй илэрхийлсэн.	1	15,607.4			1	15,607.4			1	15,607.4		
Үр дүнгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг буруу тусгасан.	1	558,336.7	1	558,336.7					1	558,336.7		
Дүн	2	573,944.1	1	558,336.7	1	15,607.4			2	573,944.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
И-баримтын бүрдүүлэлт хангаагүй ажил гүйлгээ хийсэн	1	9,104.4			1	9,104.4						
Бараа материалыг баталгаажуулаагүй	1	540.0						1	540.0			
Шаардлагагүй нөөц үүсгэсэн	1	682.0			1	682.0						
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгээгүй	1	0						1	0			
Шатахууны эхний болон эцсийн үлдэгдлийг бараа материалын тайланд тусгаагүй.	1	335.7						1	335.7			
Томилолтын төсвийг баталж, тайлан бичиж тайлагнаагүй	1	2,061.7						1	2,061.7			
Дүн	6	12,723.8			2	9,786.4		4	2,937.4			

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим системд 13 мэдээг хугацаа хоцроон байршуулсан байна.	13	-					13	-
Дүн	13	-					13	

АУДИТЫН ТАЙЛАН

БОЛОВСРУУЛСАН:

Өлзийт экаунт аудит ХХК-ийн

Ахлах аудитор

Аудиторын туслах

ХЯНАСАН:

Өлзийт экаунт аудит ХХК-ийн

Чанарын хяналтын менежер 1-р шат

Чанарын хяналтын менежер 2-р шат



Handwritten signature of the Chief Auditor

Ч.Эрдэнэжав

Б.Лхагвасүрэн

Handwritten signature of the Auditor

Ч.Оюун

Ц.Бямбажав